



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 16 өдөр

Дугаар A/249

Булган сум

Ази тивийн самбо бөхийн аварга шалгаруулах
тэмцээнд оролцох тамирчинд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Биеийн тамир спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.9, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Казахстан улсын Алматы хотод 2025 оны 04 дүгээр сарын 13-20-ны өдрүүдэд зохион байгуулагдах өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн Ази тивийн самбо бөхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчин Шаравжамц овогтой Эрдэнэ-Очирын замын зардалд 2,800,000 (хоёр сая найман зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дээрх зардлыг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

